

**АРИУТГАН ШҮҮЖ ХӨРВҮҮЛЭХ ЁСОН: БУДОН “ЧОЙНЖИН”-ИЙН  
ТОД ҮСГИЙН ТЕКСТИЙН БИЙ БОЛСОН ЯВЦ<sup>1</sup>**

Мянгад Эрдэмт

Ойрын жилүүдэд дэлхийн аль нэг газраас тод үсгийн ховор нандин дурсгалууд шинээр олдсоор байна. Тэдгээр шинэ дурсгалт бичгүүд нь тод үсгийн сурвалж бичгийн судлалын хөгжлийг урагч ахиулах нь лавтай. Ойрд бидний олж мэдсэн тод үсгийн чухал сурвалж бичгийн нэг бол Будон Ринбүүчигийн “Чойнжин” болно (доош Будон “Чойнжин” хэмээн товчилно).

2021 оны цагаан сарын үес, миний сайн найз Монгол улсын Улаанбаатар хотын Биндэрсайханы Амарсанаа өөрийн цуглуулгад байгаа тод үсгийн нэгэн судрын цөөн гэрэл зургийг надад ирүүлсэн бөгөөд мөн судрын нэр, дуртгагч, орчуулагч зэрэг бодитой асуудлуудын тухай лавлан асуусан юм. Уг судар төвөд гарчигтай, 11×41.5 см, 319 хуудас (хуудасны хоёр тал), хулсан үзэг, эхний хуудасны эхлэлтийн мөргөлийн үгийг бэх, шунх алаглуулан бичсэнийг гаргавал бусад нь цөм хар бэхээр бичсэн байна. Төвөдөөр бичсэн номын нэрийг доор ярих мэт монгол хэлнээ орчуулбал мадаггүй Будон “Чойнжин” болох нь тодорхой байна.

1975 онд Монгол улсын эрдэмтэн Х.Лувсанбалдан “Тод үсэг, түүний дурсгалууд” хэмээх номдоо Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Хэл зохиолын хүрээлэнгийн тод үсгийн хөмрөгт байсан Будон “Чойнжин”-ийн нэгэн эхийг өөрийн бүтээлдээ бүртгэн оруулахын зэргэд орчуулагч, дуртгагч нарыг дурдсан ба төгсгөл шүлгийг нь дагалдуулан сийрүүлсэн гэдэг боловч эрдэмтдийн анхаарлыг төдий л татсангүй бөгөөд ялангуяа түүнийг Будон “Чойнжин” мөн гэдгийг өдгөө хүртэл бараг мэдээгүй байсаар.

Будон “Чойнжин” болбоос Төвөдийн шашин дэлгэрсэн алдарт түүхийн зохионгуй юм. Түүний монгол орчуулгын тухай мэдээнүүд шинэ зууны эхний үеэс сая бага сага мэдэгдэж байна.

Төвийн Үндэстний Их Сургуулийн судлаач С.Сампилноров багштаны хувийн хадгаламжид Будон “Чойнжин”-ийн цорын гагц хуудам орчуулгын текст байсан бөгөөд Өлзий профессор 2004 онд “Бурхан шашны соёл түүх” сэтгүүлийн тавдугаар хугацаанд “Ойрын жилүүдэд илрүүлсэн ‘Будон шашны түүх’-ийн монгол орчуулгын тухай үнэлэлт” хэмээх өгүүлэл нийтлүүлж, судрын хэмжээ 5.2×40.7 см, хулсан үзгийн бичмэл болох зэрэг сударт холбогдох үндсэн асуудал; монгол орчуулгын онцлог; орчуулагч нь баруун монгол хүн болох ба орчуулсан цаг нь XVIII зуунаас өмнө байх тухай; хадгалагч ба хадгалагчийн гарт уг судар орсон шалтгаан зэрэг нэлээд асуудлыг авч үзжээ. Угтаа Будон “Чойнжин” болбоос монгол орчуулгын түүхэн дэх чухал сурвалжуудын нэг бөгөөд түүнийг олон улсын монгол судлалынханд алдаршуулан танилцуулсан хүн бол Өлзий профессор юм.

Доор юуны өмнө зохиогч Будон Ринбүүчи ба түүний “Чойнжин”-ийн тухай танилцуулан, дараа нь түүний дуртгагч, орчуулагч, орчуулсан цаг жич хуудам, тод хоёр текстийн харьцаа зэрэг асуудлын тухай өгүүлсүгэй.

<sup>1</sup> Энэхүү өгүүлэл нь Улсын нийгмийн шинжлэх ухааны суурь мөнгөний том төсөл “Илийн голын урсгал дагуу орон дахь өөлдүүдийн хадгалагдаж байгаа тод үсгийн дурсгалт бичгийн цуглуулга ба судлал” (зөвшөөрсөн дугаар: 18 ZDA274)-ын ширс бүтээлийн нэг.

**Нэг. Арван зүгт дуурсахуй алтан лавайн дуун: Будон Ринбүүчи хийгээд түүний “Чойнжин”**

Цаст Төвөдийн орноо бурхан шашны түүхийг туурвисан алдарт бүтээлүүд байдаг бөгөөд түүнийг “Чойнжин” хэмээдэг ажгуу. “Чойнжин” нь Төвөд орноо ихэд дэлгэрсэн шашны түүх бичлэгийн нэг төрөл болно. Бурхан шашин Монгол орноо дэлгэрэхийг дагалдан “Чойнжин” монгол хэлнээ орчуулагдсан төдийгүй бас монгол хэлээр зохиогджээ. Түүгээр үл барам зарим монгол лам нар бас төвөд хэлээр зохиосон нь бий. Юань гүрний үед Цаст Төвөдийн орны “Чойнжин” зохиогч, тухайн үеийн шашин номын үйлсэд гарамгай хувь нэмэр оруулсан хүний нэг нь БудонРинбүүчи юм.

Будон Ринбүүчи (1290-1364) болбоос Юань гүрний үеийн таван ухаанд нэвтэрсэн алдарт хувраг болно. Тэрбээр эдүгээгийн Хойд Төвөдийн хүн болно. Түүний эцэг Нянмагийн бүлэгтний нэрт лам байсан ба ээж нь бас шашны ухаанд гүн нэвтэрсэн хүн байсан болохоор тэрээр бага наснаасаа аваад бурхан шашны өндөр боловсролыг хүртсэн ажээ.

Будон Ринбүүчи Шалу хийдийн хамба байсан бөгөөд олон шавь нарыг хүмүүжүүлэн Шалугийн бүлэгтэн хэмээн алдаршсан аж. Түүний ном зохиол арвин их бөгөөд ялангуяа бурхан шашны их хөлгөн судар “Ганжуур”, “Данжуур”-ыг гарчиглах ба шүүн ариутгаж барлах ажлыг гүйцэтгэсэн нь түүний алдар нэрийг арван зүгт алдаршуулсан юм.

Будон Ринбүүчи Цалгунтан (tshal gong thang) хийдийн “Ганжуур” номыг хянан найруулах ажилд оролцсон бөгөөд Нартан ба Шалу хийдийн бичмэл “Данжуур”-ыг ариутган шүүж, дахин төрөл хуваан найруулсан нь төвөд “Данжуур”-ын хожмын хөгжилд суурилах ач холбогдолтой ажил болжээ. Түүгээр үл барам “Данжуурын гарчиг”-ийг найруулсан байна.

Будон Ринбүүчи алдарт шашны зүтгэлтэн бөгөөд бас Төвөд үндэстний түүхэн дэх нэрт орчуулагч, түүхч юм. Түүний зохионгуй 200 гаруй төрлийн 26 боть бий бөгөөд “Ганжуур”, “Данжуур”-ын ажлаас гадна түүний бас нэг алдарт төлөөлөгч зохиол бол бидний өгүүлэн бүхий Номын гарлага шашин дэлгэрсэн түүх “Чойнжин” юм.

Будон “Чойнжин” болбоос эртний Энэтхэг ба Төвөдийн оронд шашин дэлгэрсэн түүх болно. Түүнийг Будон Ринбүүчи 33 насандаа буюу 1322 онд зохиожээ. Зарим эрдэмтэд бас Будон “Чойнжин” нь Төвөдийн шашин дэлгэрсэн түүхийн эхлэл мөн гэж үздэг нь ч бий.

Будон “Чойнжин” дөрвөн анги боловч гурван гол агуулгаас бүрэлджээ. Тус зохионгуй юуны өмнө бурхан шашны ерөнхий онолын тухай хураангуйлал хийж, дараа нь бурхан шашны түүхийг өгүүлсэн байна. Үүнд Ганга мөрний ариун урсгалт эртний Энэтхэгийн орноо бурхан шашин үүссэн ба хөгжин дэлгэрсэн байдал; Төвөд оронд бурхан шашны эхийг олсон ба цаст Төвөдийн орноо шашин дэлгэрүүлсэн 93 бандида, 192 ном орчуулагч Төвөдийн хэлмэрч гүүш нарын тухай тэмдэглэсэн байдаг. Хамаг сүүлд төвөд “Ганжуур”, “Данжуур”-ын гарчгийг жагсаасан гайхамшигт зохионгуй болно. Мөн гарчиг эл зүйлийг нарийн төрөлжүүлэн хуваасан төдийгүй төрөл бүрийн номын нэрийг жагсаан, бас түүний зохиогч, орчуулагч, ботийн тоо зэргийг цөм танилцуулсан болохоор түүний үнэ цэнийг улам нэмэгдүүлж байна. Будон “Чойнжин” бол түүний өөрийнх алдар нэрийг өнөөдөр хүртэл дуурсгасаар байгаа төлөөлөгч бүтээл бөгөөд Төвөдийн судар номын түүхэн дэх аварга бүтээлүүдийн нэг болно.

**Хоёр. Хаш мэт ухаан, харьшгүй сүсэг: Тод үсгийн текстийн нэр, дуртгагч, орчуулагч, орчуулсан цаг**

Биндэрсайханы Амарсанаагийн хадгаламжид байгаа судрын төвөд гарчиг нь “bu ston chos 'byung sog sgad du gyur pa yin no”. Түүнийг монгол хэлнээ орчуулбал “Будон Чойнжин. Монгол хэлэнд орчуулсан нь энэ болой” болно. Х.Лувсанбалданы “Тод үсэг, түүний дурсгалууд” хэмээх ном дахь мэдээнээс харахад Хэл зохиолын хүрээлэнд хадгалж байгаа мөн судрын нэр нь “Сайваар одсон шажныг тодотгон үйлдэх эрдэнэ сайн зарлигийн сан ном гарахуй хэмээх” (1975:279) болно.



tonilqui mürtü sayitur oroĵi. barimi-yin arban mör tögüsken üyilede:ye paja yeke amuyulang-giyin ėindamani-yi ütür olqu boltuyai.<sup>3</sup>

Дээрх төгсгөл үгэнд доорх мэт түүхэн мэдээнүүд бий.

1. Уг судрыг дуртгагч нь Тайш ахай.

2. Орчуулагч нь Аяга тахимлаг Равжим Зая бандида.

Төгсгөлийн үгээс үзэхэд дуртгагч ба орчуулагч үндсэндээ тодорхой байна. Үүнд мөн номыг дуртгагч Тайш ахай болбоос Зүүнгарын хошуудын Очирт Цэцэн хааны хатан мөн. Тэрээр 1642 онд “Банчин хутагтын тууж”-ийг Ачит Цорж, Очирт тайжийн хамт дуртган орчуулуулсан ба 1638 оноос 1644 он хүртэлх зургаан жилд бас “Хутагт Дарь эхийн магтаал”-ыг ганцаар дуртган, мөн Очирт тайж ба Зодов нарын хамт “Бодисадын унал мөргөл хэмээх судар”-ыг дуртгасан ба тэдгээр номыг цөм Зая бандида орчуулсан тухай бид судалгаандаа хэдийн дурдаж өнгөрсөн билээ (Мянгад Эрдэмт, 2011).

Зая бандидын намтар “Сарны гэрэл”-д “ха:ni хатун таййši biji-dü mou boluqsan-du töüni tustu irö:l abun gege:ni buyidar örlüq meċin jiliyin übüliyin söül sarayin хорin-du күрċi irebei” (Сэцэн нар, 2018:16) хэмээх тэмдэглэлээс үзэхэд энэ хатан бичин жил буюу 1644 онд Биж гэдэг газар нас барсан гэдэг нь тодорхой байна.

Орчуулагч Аяга тахимлаг Равжим Зая бандида бол мадаггүй тод үсгийг зохиогч Зая бандида Намхайжамц мөн. Түүний намтар түүхийн тухай судалгаа маш их бөгөөд өнгөрсөнд бид бас тусгай судалж өнгөрсөн болохоор орчуулагчийн тухай энд нуршихгүй.

Будон “Чойнжин”-ийн төгсгөл үгэнд хэдийгээр дуртгагч ба орчуулагчийн тухай дурдсан боловч орчуулсан цагийг тэмдэглэсэнгүй. Гэвч Зая бандида 1638 онд Ойрадад буцан харьж ирсэн ба дуртгагч Тайш ахай 1644 онд нас барснаас бодвол мөн судрыг 1638 оноос 1644 он хүртэлх зургаан жилд орчуулсан гэж үзэхэд их буруудахгүй байх.

Харин 1648 онд Зая бандида тод үсгийг зохиосон болохоор Будон “Чойнжин”-г Зая бандида анх худам бичгээр орчуулаад дахин тодчилсон гэдгийг бас мэдэж болно. Ялангуяа доор худам, тод хоёр эхийн эхний нэг хуудсыг харгуулан судлах болохоор түүнээс хоёр эхийн харьцааг нэн тодорхой олж харах юм. Хэдийгээр бид Будон Ринбүүчийн “Чойнжин”-г орчуулсан цагийг тогтоосон боловч түүнийг тод үсэгт хөрвүүлсэн бодитой цагийг тогтооход бэрхтэй байна. Гэхдээ 1648 онд Зая бандида тод үсгийг зохионгуут хийсэн нэг чухал ажил нь худмаас тод үсэгт хөрвүүлэх ажил болохоор тод үсэг зохиогоод төдий удалгүй хөрвүүлсэн гэж үзэх нь зүйтэй.

Тод үсгийн судар номын үүсэн бүрэлдсэн ба хөгжин дэлгэрсэн нь төвөд, монгол тэл хэлт лам нарын оюун ухаан, ой билиг, гүн мэдлэг лугаа салшгүй нягт холбоотой болох нь мэдээж. Гэвч хас мэт ухаант, харьшгүй чин сүжигт Тайш Ахай зэрэг Ойрадын өглөгийн эздийн шашин номын хөгжилд үзүүлсэн ач гавьяаг бас мартаж болохгүй. Тэдний эрхэмсэг дээд биеийн гарал, нийгэм нийт дэх алдар хүнд, шашин номд хандсан хоёргүй үнэнч сэтгэл, харамгүй өглөг байсан болохоор шашин ном сая Ойрадын бүх нийгэмд саадгүй дэлгэрч чадсан юм. Тийм болохоор Ойрадын бурхан шашны судар номын үйлсийг дурдах үед тэдний үнэн алдрыг бас эргэн дурсах нь зөвтэй.

### **Гурав. Судар номыг шинэтгэн ариутгах ёсон: Тод үсгийн текстийн хөрвүүлгийн нэгэн гол зарчим**

Дээр бид Зая бандида 1638 оноос 1644 оны хооронд Будон “Чойнжин”-г төвөд хэлнээс монголчилсон ба мөн худмаас тод үсэгт хөрвүүлсэн тухай ярьж өнгөрөв. Гэхдээ худам, тод хоёр эхийг нарийн тулган үзэхэд тэр нь энгийн нэг зүйлийн монгол үсгээс нөгөө нэг монгол

<sup>3</sup> Гар бичмэл, бу ston chos 'byung sog sgad du гууг pa yin no , 11×41.5 см, 319 хуудас (хуудасны хоёр тал), хулсан үзэг, Биндэрсайханы Амарсанаагийн хувийн хадгаламжид бий. 318a-319a.

үсэгт буулгасан дөхөмхөн хөрвүүлэг огт биш, харин шүүн ариутгасан бурхан шашны судар номын орчуулгын ухаанд холбогдох эртний гайхамшигт уламжлал мөн хэмээн үзэхэд хүргэж байна.

Шүүн ариутгах гэдэг нь бурхан шашны түүхэн дэх судар номын алдаж оносон бурууг хамгийн найдвартай эхүүдтэй нарийн тулган шүүж дахин найруулан шинэчлэх төвөг будилаантай ажил юм. Шүүн ариутгах нь бас бурхан шашны судар номын орчуулгын үйлсийн чанар чансаа, хөгжлийн төвшин зэргийг харуулдаг. Ариутган шүүхэд их хэвчээний олон мэргэд оролцон, олон боть судрын эхүүдийг хамгийн найдвартай эх лугаа тулган шүүж засах буюу дахин найруулан орчуулж эмхэтгэн дэглэх хатуу ажил болно. Бага хэвчээний шүүн ариутгах ажил нь ганц хоёр хүн буюу хэдэн мэргэд нийлээд ямар нэгэн судар номыг тулган шүүж дахин ариутгах үүргийг гүйцэтгэдэг юм. Бурхан шашны орчуулга хөгжөөд зохих өндөрт хүрвэл сая иймэрхүү ажил явагддаг. Тийнхүү шүүн ариутгах үйлс нь тодорхой цаг үеийн шашин номын үйлсийн хөгжлийн байдлыг ойлгохын чухал нэг үндсэн нөхцөл болдог.

Будон “Чойнжин”-ийн тод үсгийн текстийн ирэлтийн асуудлыг улам тодорхой өгүүлэхийн тулд Будон “Чойнжин”-ийн худам, тод хоёр текстэд харгуулга хийе. Гэхдээ өгүүлэлд холбогдох Будон “Чойнжин”-ийн худам үсгийн текстийн тухай энд бага сага тайлал хийх нь чухалтай гэж бодож байна.

Дээр нэгэнт ярьсан Будон “Чойнжин”-ийн нэг худам эх С.Сампилноров багштаны хувийн хадгаламжид байв. Би 1988 онд Төвийн Үндэстний Дээд Сургуулийн Үндэстний нэгдүгээр салбарын монгол хэл, утга зохиолын тусгай мэргэжлийн чиглэлээр суралцах болсон бөгөөд багштан тухайн үед бидэнд “Монголын зан ааль”, “Зохион бичлэг” гэх хичээлүүдийг зааж байв юм.

С.Сампилноров багштантай нутаг нэгтний хувьд тухайн үед багштан өөрийн аар саар ажилд байнга намайг дуудан хавсеруулдаг байсан ба 1989 оны 4 сарын эхээр багштан намайг дуудан мөн судар ямар судар болохыг мэдэхгүй байна, гэвч маш ховор ном гээд хэвлүүлэх санаатай, цаасанд дахин буулгах санаатай боловч өөрөө цаг зав алга болохоор гараар хуулан бичих ажлыг надад даалган хийлгэв. Үнэнийг хэлэхэд тухайн үед судар номтой анх танилцаж байсан ба өөрийн хуулан бичиж байгаа судар чухам ямар ном байсан гэдгийг тэр үед огт мэдэхгүй байсан юм. XX зууны 80, 90-ээд оны үед хэвлэлийн үйлс одоогийнх шиг хөгжөөгүй бөгөөд сурвалж бичгийг гэрэл зургаар хэвлүүлэх тохиолдол маш цөөн, харин уг сурвалжийг голцуу дахин үсэг өрөөд хэвлүүлдэг байсан юм. С.Сампилноров багштаны гараар хуулан буулгах ажлыг хийлгэж байсны зорилго нь ч түүнийг хэвлэлийн хороонд тушаан тугалган бараар хэвлүүлэхийн төлөө юм.

Би эхний 50-аад хуудсыг хуулан бичээд амралтаар нутаг буцав. Намрын хугацаа эхлэнгүүт залган хуулах гэсэн боловч багшийн найдлагаар нэгэнт хуулсан 50 хуудсыг хоёр удаа харгуулах ажлыг гүйцэтгэжээ. Шинэ гэрт нүүх зэрэг олон ажил байсан болохоор багштан миний хуулсан эхийг надад хадгалуулж байсан бөгөөд дахин дурдсангүй болохоор залган хуулсангүй бөгөөд нөгөө нэгэнт хуулсан эх миний хадгаламжид одоо хүртэл байсаар бий. Гэвч харамсалтай нь 2001 онд С.Сампилноров багштан гэнэт нас барсан бөгөөд өдгөө тэрхүү ховор нандин судрыг чухам багштаны гэр бүлийн хэнийх нь гарт хадгалж байгааг сайн мэдэхгүй байна.

Доор бид зөвхөн миний гарт байсан 1989 оны хуулмал эх ба Биндэрсайханы Амарсанаагийн хадгаламжид байгаа тод үсгийн текстийг харгуулах болно. Тийнхүү миний хуулсан эхийг А дэвтэр, Биндэрсайханы Амарсанаагийн хадгаламжид байгаа тод үсгийн текстийг В дэвтэр хэмээн товчлон нэрлэж, хоёр дэвтрийг харгуулан үзье. Хэлэлгээнгүй сурвалж бичгийн судлалд хамгийн найдвартай уг эхийг хэрэглэх хатуу зарчим бий. Гэвч багштан нэгэнт нас барсан ба одоо хүртэл мэдэгдээд байгаа тэрхүү ховор нандин цорын гагц гар бичмэлийг олж үзэхэд бэрхтэй байна. Хэдийгээр миний өөрийн хуулсан эх орчин үеийн гар хуулмал гэдэг боловч тухайн үед багштаны хэлснээр хоёр удаа хянан тулгасан болохоор мэдээж уг эхтэй төдий их



зөрөөгүй. Одоогийн нөхцөлд уг эхийг олж үзэхээс өмнө өөрийн хуулсан эхийг ашиглахаас өөр аргагүй гэдгийг энд мөн онцгойлон тодорхойлъё.

Үүнд А дэвтрээр суурь дэвтэр болгож, хоёр дэвтэрт дутуу байгаа зүйлийг //, хоёр дэвтэрт гарсан адил бус үгийг 【】, байр нь солигдсон үг өгүүлбэрийг {}, илүү нэмэгдсэн үг үсгийг + тэмдгээр тус тус тодорхойлон үзүүлэв. А, В хоёр дэвтрийн эхний 50 хуудсыг их төлөв харгуулж үзэхэд худмаас тодчилох явцад ариутган шүүсэн ба хөрвүүлсэн онцлог их төлөв тодорхой ажиглагдаж байна. Мөн зөвхөн эхний нэг л хуудсыг тулган харьцуулж үзэхэд бидний судалгаанд хэрэгтэй найдвартай дүнг олж болох болохоор энд дөхмийг бодож А, В хоёр дэвтрийн эхний хуудсыг л тулган харьцуулав.

- 01a01 namo □ B □ // // // // // □ gürü manzu\_gho\_qa\_ya  
 01a02 şirisayibar\_oduysan-i şasin-i todudqan  
 01a03 üiledküi erdini sayin jarliy-yin sang  
 01a04 nom-yin □ B □ // // // // // □ yarluу\_a □ B □ yarqui □ kemekü. ilgün\_tegüs ün-e  
 01a05 ülegsен saki\_a arslan-dur mörgümüi::  
 01a06 alimad sedkil egüskegsen buyan-u  
 01a07 çiyulyan rasiyan idege\_tü-eçe  
 01a08 boluysan berke emgeniküi üile külicëküi  
 01a09 -ber çoy jibqulang badarangyui. erdini  
 01a010 -yin mön □ B □ // // // // // □ çinar. { yurban bey\_e-yin  
 01a011 muqurtu kürtin} □ çaylaşi ügei irtügel doluyan  
 01a012 üyetü □ B □ // // // // // □ qurdun\_a yabuqui □ +tögüsün □ baril bariqu-yin  
 01a013 qubčasun-aça qayaçaysan-iyar.  
 01a014 qoyar tüidker-yin usu bariyci-aça  
 01a015 qayaçaysan şibayun-u ayuu mör\_tü  
 01a016 kötel\_ün uryun Şinggeküi yabudal-yin  
 01a017 yosun eldeb-iyer busud-yin tusa  
 01a018 üiledügküi. gkir ügei jarliy-yin gerel  
 01a019 qalayun jali\_tu □ B: tai □ jayun mingyan  
 01a020 gerel-yin tour tegüs\_ün arban жүг

Дээрх харгуулгаар дамжин А, В хоёр дэвтрийн харьцааны тухай доорх зүйлсийг улам тодруулан авч үзье.

1. В дэвтрийн эхний хуудасны эхлэлийн хэсгийн дээд талын өнцөг бага урагдсан байна. Тийм болохоор хамгийн эхний үсэг урагдан гээгдсэн цаастай хамт алга болжээ. Гэвч түүний дараах үсэг нь “gürü manzu\_giu\_га” болохоор урагдан гээгдсэн үсэг нь “namo” болох нь тодорхой. “Namo gürü manzu\_gho\_qa\_ya” бол бурхан шашны судар номын эхлэлтэд байнга тохиолддог тусгай үг болохоор В эхэд түүнийг гээн орхисон биш, харин цаас урагдан тасрахад гээгдсэн гэдгийг мэдэж болно. Ялангуяа А дэвтэрт “namo” гэж бичиж байгаа нь бидний үзэлтэд чухал баримт болох учиртай.

2. А дэвтэрт “номын гарлага” гэдгийг В дэвтэрт “ном гарахуй” хэмээн бичсэн байдаг. Гэхдээ В дэвтрийн төгсгөл үгэнд харин сольсонгүй бас “гарлага” хэмээн бичсэн нь харагдана<sup>4</sup>. “Номын гарлага” ба “ном гарахуй” гэдэг нь адил утгатай болно. Түүнийг монгол судар номын орчуулгад эртнээс ингэж адил бусаар орчуулсаар ирсэн юм. Тод үсгийн сурвалжид түүнийг мөн хоёр янзаар орчуулсаар ирэв. Зая бандидын намтар “Сарны гэрэл”-д түүний “Барс жилээс

<sup>4</sup> Гар бичмэл, bu ston chos 'byung sog sgad du gyur pa yin no, 11×41.5cm, 319 хуудас (хуудасны хоёр тал), хулсан үзэг, Биндэрсайханы Амарсанаагийн хувийн хадгаламжид бий. 318a.

барс жил хүртэл” орчуулсан судар номыг дурдахад “Ном гарахуй” (Сэцэн нар, 2018), 1661 онд Сэнгээ хатантайгаа ном орчуулах тухай дурдсанд “Номын гарлага” хэмээн хоёр янзаар хэрэглэж байв (Сэцэн нар, 2018:34). Бас Сойвон Сайн-Эрдэнэ (Раднаабадраа)-ийн төвөд хэлээс орчуулсан Сономжалцаны түүхийн зохионгуй “Тэгээн толь”-ийн эхний хуудсанд номын нэрийг “Тэгээн толийн тууж оршив” хэмээн бичиж байгаа боловч гаргалгад “Шажин өргөжин дэлгэрүүлэн үйлдсэний тууж ном гарахуй тодорхой толь” хэмээн “гарлага” биш “гарахуй”-г хэрэглэсэн байна<sup>5</sup>. Тийнхүү 17 дугаар зууны үед ойрадууд мөн үгийг хоёр янзаар хэрэглэж байсан ба “номын гарлага” гэдэг үгийг худмаас тодчилох явцад дахин “ном гарахуй” хэмээн зассан гэдгийг мэдэж болно.

3. “yurban bey\_e-yin muqurtu kUrUn” нь А дэвтэрт “čaylasi ügei”-ийн өмнө байхад, В дэвтэрт харин “erdeni-yin činag” гэдгийн өмнө орсон байдаг. Энэ бол тодчилох явцад хийсэн чухал засалт мөн. Мөн ч бидний тод текст бол шүүн ариутгасан эх гэж үзэхийн хамгийн чухал баримт болно. Даруй А дэвтэрт худам үсэгт “Эрдэнийн мөн чанар гурван биеийн мухарт хүрэн цаглашгүй” хэмээн орчуулсан байхад В дэвтэрт “Турван биеийн мухарт хүрсэн эрдэнийн чанар цаглашгүй” хэмээн байрыг нь солин тодчилсон байдаг. Энэхүү бадаг үг уг төвөд эхэд “sku gsum mthar phyin gin chen rang bzhin drag yas smon lam myur 'gro bdun ldan gzung 'dzin gos bral bas” гэж байдаг<sup>6</sup>. Үүнд А, В хоёр дэвтрийг төвөд эхтэй нь тулган үзэхэд В дэвтэрт “Турван биеийн мухарт хүрсэн эрдэнийн чанар цаглашгүй” гэсэн нь төвөд эхтэй нэн ойртсон, үг дараалан үгчилсэн орчуулга болно. Мөн бадаг үг бурхан багш Шагжамунийг магтсан болох нь илэрхий. Үүнд “эрдэнэ” гэдэг нь хүссэн бүхнийг хангадаг чандмань эрдэнийн товчилсон нэр. “Турван бие” гэдэг нь бурхан багшийн номын бие, хувилгаан бие хийгээд төгс эдлэлийн бие болох юм. Тиймээс дээрх бадаг үг бурхан багшийн гурван биеийн цаглашгүй ид хүчний магтаал болно.

Төвөд хэлний зүйн хувьд тодотгол нь өмнө нь орох биш монгол хэлтэй яг эсрэг тодотгогчийнхоо хойно нь явдаг. Тийм болохоор А, В хоёр дэвтрийн аль нь зөв орчуулга болох гэдэг асуудал бас аяндаа гарч ирнэ. Харьцуулан үзэхэд А, В хоёр дэвтэр аль аль нь буруу орчуулга биш. А дэвтэр илүү монголжуу болохоор “Эрдэнийн мөн чанар” гэдэг тодотголыг өмнө нь тавьсан байхад В дэвтэр үгчилсэн орчуулгын зарчмыг илт баримталсан болохоор “эрдэнийн чанар” гэдгийг төвөд хэлний зүйн зарчим ёсоор хойно нь тавьсан байна. Хэрвээ төвөд эхтэй нь тулган шүүсэнгүй бол В дэвтэр нь А дэвтрийг худмаас тодчилох явцад иймэрхүү засалт оруулах боломж бараг үгүй юм. Түүгээр үл барам В дэвтэр бас А дэвтэрт гарсан “мөн чанар” гэдэг үгийг “чанар” хэмээн сольжээ.

Төвөд эхэд “мөн чанар” гэдгийг “rang bzhin” (རང་བཞིན) хэмээн бичдэг. Мөн үгийг монголчууд хэд хэдэн янзаар орчуулсаар ирэв. “Мэргэд гарахын орон”-ы Мадхъямакийн аймгийн 14 дүгээр нүүрийн дээд, шинэ хуучин дохионы аймгийн 5 дугаар нүүрийн дээд, Авхид Дармын аймгийн 16 дугаар нүүрийн дээд зэрэгт “өвөрчлөн”, Шинэ хуучин дохионы аймгийн 10 дугаар нүүрийн дээдэд “төрөлх” хэмээн тус тус орчуулсан байна. “rang bzhin” гэдгийг монгол хэлэнд бас “араншин” гэж орчуулсан нь харагддаг. Түүний үндсэн утга нь монгол хэлэнд “мөн чанар” бөгөөд олонх тохиолдолд “мөн чанар” хэмээн орчуулсан нь бий. Тийнхүү А дэвтэр дахь орчуулга буруу биш. В дэвтэр харин түүнийг нэнд төгөлдөр болгон товчилж “чанар” хэмээн авсан нь нэг л үсгийн зөрүү боловч нэлээд хянан бодсоны дараах засалт гэж үзвэл зохино.

4. В дэвтэрт “üyetü” гэдэг үг орхигдсон байна. Өдгөө хэдийгээр А дэвтрийн найдвартай гэрэл зургийг олж үзээгүй боловч олон жилийн өмнө миний бие түүнийг хуулан бичих явцад “үет” хэмээн буулгасан ба буулгасны хажууд мөн үсгийн оронд өөр нэг үсэг байсан ба түүнийг баллан “үет”-ийг бичсэн болохоор чухам ямар үсэг болохыг дахин нарийвчлах чухалтай гэж тодорхойлсон зүйл бий.

<sup>5</sup> “Тэгээн толийн тууж оршив”. Тод үсэг, хулсан үзэг, 14×50см, 120 хуудас (хуудасны хоёр тал), Өвөр Монголын Нийгмийн шинжлэх ухааны хүрээлэнгийн номын санд хадгалж байна.

<sup>6</sup> rin chen grub/ bde gshegs bstan pa'i gsal byed chos kyi 'byung gnas/ bris ma/ khyon bsdoms shog ngos/[244] bod kyi nang bstan dpe tshogs lte gnas/ BDRC W3CN22975:1a01-1a02.P9.

Тод эхэд түүнийг хасан хаясан ба төвөд эхтэй нь тулган үзэхэд мөн хэсэгт байх “үет” гэдэг үг илүүц болсон нь тодорхой байна. Тийнхүү тод эх буюу В дэвтэр түүнийг хасаж хаясан нь зүгээр нэг дөхөмхөн үг үсгийг гэж орхисон зүйл биш байх.

В дэвтэрт “tögüsün” гэдэг үг А дэвтрээс илүү болсон байна. “tögüsün” гэдэг үгийн өмнө нь “долоон хурднаа явагч” гэдэг үг бий. Морины онжид нэрт “долоон төгөлдөр” гэдэг үг байдаг. Хэрвээ тэр нь морины онжид нэр байсан болохоор “төгөлдөр” гэдгийн оронд “Төгссөн” гэдэг үгийг хэрэглэсэн бололтой. Мөн асуудлын тухай цаашид анхааран үзэх чухалтай.

5. А дэвтэрт “jali\_tu” гэдгийг В дэвтэрт “jali\_tai” болгон зассан байна. “jali\_tu/tai” гэдгийн өмнө нь “хиргүй зарлигийн гэрэл” хойно нь “зуун мянган гэрлийн тор түүсэн” гэдэг үг байгаа болохоор В дэвтэрт “jali\_tai” хэмээн нэг л дагаврыг сольсон боловч өгүүлбэрийн орчноос ажиглахад улам найдвартай болсон гэж үзэхэд хүргэж бий.

Харин Зая бандида 1648 онд тод үсгийг зохиосны дараа өнгөрсөнд худам бичигт орчуулсан судар номыг дахин тодчилох явцад зүгээр нэг хоёр зүйлийн монгол үсэгт дөхөмхөн хөрвүүлэг хийж байсан гэж ойлгож болохгүй. Өдгөө Зая бандидын худам, тод хоёр зүйлийн орчуулгын эх маш цөөн тохиолдож байна. Зөвхөн бидний гарт олдсон энэхүү сурвалжийн нэг л хуудасны харгуулгаас ажиглаж үзэхэд, худмаас тодчилох явцад дан үгээс дагавар, цаашид мөр бадаг хүртэл нарийлаг шүүн засалт оруулсан гэдэг нь тодорхой ажиглагдана. Бас А, В хоёр дэвтрийн эхний 50 хуудасны бусад хуудсыг харгуулан үзэхэд дээрх лугаа ижилхэн засалт оруулсан зүйлс байнга тохиолдож байна. Хэрвээ худам орчуулгын эхийг төвөд эхтэй нь тулган шүүсэнгүй бол ингэж нарийн засвар хийхийн боломж бараг үгүй юм. Тийнхүү В дэвтэр буюу тод текст болбоос мөн судрыг худмаас тодод хөрвүүлэх явцад дахин төвөд эхтэй нь тулган шүүн ариутгасан эх мөн. Түүнээс худам текстийг тод болгон хөрвүүлэх үед баримталсан гол зарчмын нэг бол төвөд эхтэй нь тулган дахин шинэтгэн шүүн ариутгах ажил байсан гэдгийг мэдэж болно. Зая бандидын амьдарч байсан цаг үед их хэмжээний судар номыг орчуулж байсан гэдэг нь тодорхой боловч чухам ариутган шүүх ажлыг хийж байсан уу үгүй үү? Өдгөө болтол мөн асуудлын тухай анхаарсан эрдэмтэн үгүй байсаар. Тийнхүү Зая бандидын орчуулгын үйлсэд холбогдох нэгэн нууцыг бид Будон “Чойнжин”-ийн тод текстийн судалгаагаар дамжин илрүүлэв.

Өнгөрсөнд ойрадууд хийгээд тод үсгийн шүүн ариутгасан үйлс Галданцэрэн ханы үед эхэлсэн гэдэг тухай би өгүүлж өнгөрсөн юм (Мянгад Эрдэмт, 2019). Гэвч Будон “Чойнжин”-ийн худам, тод текстийн харьцаанаас ажиглахад тод үсгийн шүүн ариутгасан үйлс Галданцэрэн ханы үед эхэлсэн гэдэг бидний өнгөрсөн үзэлт бараг асуудалгүй боловч ойрадуудын бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлс Галданцэрэн ханы үе биш, харин Зая бандидын амьдарч байсан цаг үед нэгэнт эхэлсэн юм байна. Даруй ойрадуудын бурхан шашны судар номын орчуулгын шүүн ариутгах үйлс аль эрт тод үсгийг зохиосон тэр цагаас нэгэнт эхэлсэн байжээ. Тэр нь худам судар номыг тод үсэгт дахин хөрвүүлэх явцад үүссэн бөгөөд монгол бурхан шашны судар номын түүхэн дээр ч цөөн тохиолдох онцгой үзэгдэл юм. Мөн Зая бандидын орчуулгын үйлсэд холбогдох бидний ерөөс анхаараагүй чухал асуудлын нэг мөн.

Монгол бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлсийн эхлэлийн цэг тодорхой бус. Өдгөө түүнийг чухам хэзээнээс эхэлсэн гэдгийг тодорхой хэлэхэд бэрх. Гэвч XVII-XIX зууны Монгол бурхан шашны судар номын ариутган шүүх үйлсийн хөгжлийн ул мөр их тодорхой юм. Монголчуудын бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлсийг эргэцүүлэн үзэхэд монгол судар бичгийг энэтхэг, төвөд, хятад, уйгар зэрэг уг судар буюу бусад холбогдол бүхий машид ариун эхүүд лүгээ хянан харгуулж, шүүн ариутгах ажил бол нэг гол урсгал байсан юм. 1717-1720 оны шунхан барын “Ганжуур”, бас XVIII зууны гуч дөчөөд оны үеийн Галданцэрэн ханы тод үсгийн судар номыг шүүн ариутган, хэвд сийлэн хэвлүүлсэн зэрэг нь энэхүү системд багтана. Шунхан “Ганжуур” бол монголчуудын шүүн ариутган хэвлүүлсэн бурхан шашны судар номын оргил бүтээл мөн. Гэхдээ Зая бандида худмаас тод үсэгт судар номыг хөрвүүлэх явцад шүүн ариутгасан нь шунхан “Ганжуур”-аас хэдэн арван жилийн өмнө



байсан бөгөөд монгол судар номын шүүн ариутгах үйлсийн нэгэн чухал урсгал болох шүүн ариутгаж хөрвүүлэх шинэ загварыг үүдсэн болохоор монгол бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлсийн агуулгыг улам баялаг болгожээ. XVII-XVIII зууны дундаж сүүлч үед Ойрад нутаг ба Бээжин дэх бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлс бууралтын цаг үед орох үес буриадууд XIX зуунаас монгол бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлсийг залгамжлан хөгжүүлсэн бөгөөд хамгийн чухал төв болсон байдаг.

XIX зуунд буриадууд голцуу Бээжин модон барыг ариутган шүүж хэвлүүлж байснаар барахгүй Цахарын цагаан уулын сүмийн модон бар зэрэг зарим монгол нутагт нэгэнт хэвлэсэн буюу зарим бичмэл судруудыг төвөд хэлтэй нь тулган шүүн ариутгаж байсан ба ялангуяа зарим тохиолдолд ᠙, ү-ийн махбодын дүрсийг солин хэвлүүлсэн өөрийн орон нутгийн өвөрмөц онцлогоороо ялгардаг. Буриадууд шашны их хөлгөн судар “Алтангэрэл”, “Хутагт ихэд тонилгогч”, “Бодь мөрийн зэрэг” ба хутагт хувилгаадын намтар “Мялын намтар” зэргээс гадна бас “Рашааны Дусал”, “Молон тойны судар”, “Саран хөхөө шувууны намтар”, “Субашид” зэрэг нэлээд бурхан шашны судруудыг шүүн ариутган хэвлүүлжээ. Түүнээс гадна тухайн үед говийн өмнө ба умард ерөөс модон бараар хэвлэгдээгүй байсан Зая бандидын орчуулсан “Чойжид дагинын тууж” зэрэг бичмэл судрыг ариутган шүүж модон бараар хэвлүүлсэн байдаг.

Дээр ярьсан мэт өдгөө монголчуудын бурхан шашны судар номын шүүн ариутгах үйлс хэзээ эхэлсэн бэ гэдэг асуудал тийм тодорхойгүй байна. Ялангуяа Юань гүрэн ба Умард Юань улсын үед иймэрхүү шүүн ариутгах ажил явагдаж байсан уу үгүй юу? Тодорхой баримт олодоогүй байсаар. Харин XVII-XIX зуун бол монгол судар номын шүүн ариутгах үйлсийн өрнөн хөгжсөн цаг үе мөн. Тухайн үед Бээжин, баруун хязгаарын Ойрад ба Буриад бол түүний гурван гол төв болно.

XVII зууны дундаж үеэс XVIII зууны гуч дөчөөд он бол ойрадуудын шүүн ариутгах үйлсийн алтан үе мөн. Ойрадууд монгол судар номыг төвөд эхтэй нь тулган шүүх уламжлалт шүүн ариутгах аргаар судар ном бүтээж байсан бөгөөд тод үсгийг зохиосны дараа нэг монгол үсгээс нөгөө монгол үсэгт хөрвүүлэх явцад шүүн ариутгах шинэ загварыг үүджээ. Зүүнгарын мөхлөөс болж ойрад дахь тод үсгийн ариутган шүүх үйлс зогссон гэдэг боловч Бээжин ба Буриадад мөн үргэлжлэн явагдаж байсан нь монгол бурхан шашны судар номын хөгжилд ихээхэн нөлөөлсөн юм.

Зая бандида 1638 онд Төвөдөөс мордон Зүүнгартаа буцаж, 1648 онд тод үсгийг зохиох болтол Зүүнгарын нутагт бараг 10 жил худам бичгээр судар ном орчуулах ажлыг гүйцэтгэжээ. Өдгөө түүний худам орчуулгаас “Маань амбу” тэргүүтэн цөөн судар л худам тод хоёр эхээр уламжлагдан иржээ. Тийнхүү тод үсгийг зохиох үед Зая бандидын худам орчуулгын үндсэн тогтолцоо нэгэнт бүрэлдэн тогтчихсон байх ёстой. Гэвч тод үсгийг зохиосны дараа худам судрыг тодчилох явцад дахин ариутган засах шаардлага гарсан байна. Гэвч өнөөдөр хүртэл энэхүү чухал асуудлыг ерөөс анхааран судлаагүй байсан нь доорх мэт шалтгаанаас болсон бололтой.

Юуны өмнө, олонх тохиолдолд судар номыг шүүн ариутгахыг дурдагсад нь хаан хатан, хан зэрэг ихэс ноёд байдаг ба шүүн ариутгасны дараа модон бараар хэвлэдэг. Тийм мөртлөө судар номын төгсгөлд тэдний алдар нэрийг зүй ёсоор тэмдэглэн үлдээдэг зуршил бий. Гэвч өдгөө хүртэл олдсон Зая бандидын үед орчуулсан тод үсгийн судар номын төгсгөлд иймэрхүү тэмдэглэл ерөөс харагдахгүй. Тэдгээр судар номын төгсгөлд Зая бандида буюу бусад орчуулсан хүмүүсийн нэр зүй ёсоор гарч байдаг боловч тэднийг зөвхөн судар номыг орчуулсан хэмээн ойлгохоос биш харин нэлээд судар номыг чухам шууд төвөд хэлнээс тодчилсон уу? эсхүл худмаас тод үсэгт хөрвүүлсэн үү? ялгахын аргагүй болжээ. Мөн өдгөө болтол Зая бандидын амьдарч байсан цаг үед Ойрадуудын модон барын тухай сураг занги огт мэдэгдээгүй байсаар. Зая бандидын амьдарч байсан цаг үед бурхан шашны судар номыг худам үсэгт орчуулах, тод үсэгт орчуулах юм уу эсхүл худмаас тодчилох ажлыг хийж байсан боловч модон барын хэвд

сийлэн барлаагүй байсан байна. Хэрвээ ариутган шүүж барласан байсан бол төгсгөл үгэнд мөн асуудлын тухай найдвартай мэдээнүүд дагалдан гарах ёстой.

Дараа нь, Зая бандидын зохиосон тод үсэг хэдийгээр уламжлалт худам үсгийг засан сайжруулсан монгол үсэг гэдэг боловч нэгэн биеэ даасан үсэг бичгийн систем болсны хувьд өөрийн өвөрмөц онцлог бий. Худмаас тодчилох явцад тэр зарчимд нийцүүлэн буулгах нь ойлгомжтой хэрэг. Бас нөхөн өгүүлэхэд Зая бандида тод үсгийг зохиосны дараа эрхбиш тод үсгээр судар ном орчуулах болохоор тод үсгийн судар номын орчуулгын тогтолцоог бий болгох хэрэгтэй. Тийм болохоор худмаас тодчилох явцад зарим өөрчлөлтийг хийх нь ойлгож ядмаар зүйл биш.

Гуравдугаарт, мөн өдгөө хүртэл бидний гарт Зая бандидын орчуулсан худам судрын текст хэдхэн олдоод байна. Тийм мөртлөө тэдгээр нь дэлхийн олон газар хадгалагдаж байгаа болохоор олж үзэх буюу эрдэм шинжилгээний ажилд ашиглахад бэрх. Нэнд түүнийг тод тексттэй нь харгуулан судлах боломж маш бага. Тийнхүү найдвартай түүхэн материалын хомс нь бас ч өдгөө хүртэл мөн асуудлыг судлаагүй олтгойлсны гол нэгэн шалтгаан буй за.

Тийнхүү 1648 онд Зая бандида тод үсгийг зохиосны дараа хийсэн томоохон ажлын нэг бол тод үсгээр ном орчуулах, бас худам үсгийн орчуулгаа ариутган шүүж тодчилох байсан гэдгийг мэдэж болно. Энэ бол Зая бандидын орчуулгын үйлс лүгээ холбогдох хамгийн чухал асуудлын нэг юм.

Түүхэнд монголчууд нэлээд хэдэн зүйлийн монгол үсгийг хэрэглэж байсан гэдгийг бид сайн мэднэ. Тийм болохоор аль эрт XIII-XIV зууны үед нэг зүйлийн монгол үсгээс нөгөө нэг зүйлийн монгол үсэгт харилцан хөрвүүлэх ажил явагдаж байв. Өдгөө олдсон цөөн баримтаас ажиглахад 1269 онд дөрвөлжин үсгийг зохиосны дараа монголчууд уйгуржин монгол үсэг ба дөрвөлжин үсгийн хооронд “Субашид”, “Мэдэгдэхүүнийг бэлгэтэйгээ гийгүүлэгч нэрт судар” зэргийг харилцан хөрвүүлж байв. Хэдийгээр тухайн үед ямар ямар судар номыг харилцан хөрвүүлж байсан гэдэг нь тийм тодорхой биш боловч хоёр зүйлийн монгол үсгийн хооронд хөрвүүлгээ хийж байсан гэдэгт ямар ч эргэлзэх хэрэггүй юм. Мөн ч өдгөө олдсон тэдгээр цөөн хэдхэн уйгуржин монгол үсэг ба дөрвөлжин үсгийн судар ном нь тамтаг болсон тасархай хуудсууд болохоор чухам худам үсгээс тод үсэгт хөрвүүлэх лугаа адил шүүн ариутгаж хөрвүүлж байсан эсэхийг тасархай хэлэхэд бэрхтэй. Юу ч гэсэн Зая бандидын худам үсэгт орчуулсан судар номоо дахин тод үсэгт хөрвүүлэх явцад хийсэн ариутгал бол монгол бурхан шашны судар номын түүхэн дэх өөрийн өвөрмөц онцлог бүхий онцгой үзэгдэл юм. Энэхүү асуудал тухайн үед худмаас тодчилох хөрвүүлгийн үндсэн зарчим, Зая бандидын орчуулгын тогтолцоо ба тод үсгийн сурвалж бичгийн бий болж бүрэлдсэн хийгээд монгол бурхан шашны орчуулгын түүх зэрэг чухал асуудалтай шууд холбогддог.

Бидний гарт олдсон тод үсгийн Будон “Чойнжин” ба түүний худам орчуулгын хоёр текстийг харгуулахаар дамжин, Зая бандидын орчуулгын үйлсэд холбогдох чухал асуудлын нэг тодорхой болсон гэж бодож байна. Гэвч эрхбиш дурдах хэрэгтэй зүйл бол Будон “Чойнжин”-ийн тухай цаашдаа судлах чухалтай зүйл бас бага бус байсаар. Ялангуяа Будон “Чойнжин”-ийн монгол орчуулгын судлал сая эхэлж байгаа гэдгийг эрхбиш дурдах хэрэгтэй. Тийнхүү мөн асуудлын тухай хойшдоо нэлээд олон талаар судалгааг өрнүүлэх хэрэгтэй.

Үүнд хойшдын судалгаанд Будон “Чойнжин”-ийн худамчилсан эхийн орчуулга хийх үес хэрэглэсэн төвөд эх нь ямар дэвтэр болох ба төвөд, худам эхийг харьцуулан орчуулгын үндсэн тогтолцоог гаргах, Монгол улсад байгаа хоёр зүйлийн тод эхийг харилцан тулган харгуулах, худам эх ба тод эхийг улам нэг алхам бүх талаар харьцуулах зэрэг бодитой ажлуудыг хийх хэрэгтэй байна. Бас М.С.Өлзий профессорын судалгаанаас ажиглахад Будон “Чойнжин”-ийн худам текст нэлээд дутуу гэдэг нь мэдэгдэж байна. Мөн орчуулгыг тодчилох явцад тэдгээр асуудлуудыг шийдвэрлэсэн эсэх зэргийг цаашид нарийвчлах чухалтай. Тод эхийн хуудас хэмжээ нэлээд их болохоор бүрэн шүүн ариутгаж нөхөн орчуулсан боломж ч их бий. Бас М.С.Өлзий

профессорын мэдээлснээр худам эхийн завсар бас хаяа тод үсэг тохиолддог. Тэр нь яг тодчилох үеийн ашигласан анхны худам эх байж ч болзошгүй. Өлзий профессорын мэдээнээс үзэхэд худам эх дутуу бөгөөд засалт оруулсан газар ч бий. Түүгээр үзэхэд тод үсгийг анх зохиосон гэдэг боловч түгээмжилж чадаагүй эхний үед худмаар судар номоо орчуулаад дахин тодчилох явцад засан төгөлдөржүүлж байсан ч юу магад. Мөн асуудлыг худам, тод хоёр эхийг нарийн харгуулбал мэдэж болно. Тийнхүү Будон “Чойнжин”-ийн монгол орчуулгын судлал арай хийж эхэлж байгаа бөгөөд хойшдын судалгааны зорилго, чиг хандлага ч үндсэндээ тодорхой гэж хэлж болно.

Өдгөө хүртэл Ойрадуудаас гадна зүүн монголд Будон “Чойнжин”-г орчуулсан мэдээ ерөөс олдоогүй байсаар. Тийнхүү монгол хэлэн дэх Будон “Чойнжин” нь Монгол-Төвөдийн соёлын харилцаа, монгол орчуулгын түүх зэргийг судлахад ховор нандин материал болох юм.

### **Номзүй**

**Лувсанбалдан Х.** 1975. *Тод үсэг, Түүний дурсгалууд*. Улаанбаатар.

**Мянгад Эрдэмт.** 2011. *Равжамба Зая бандида Намхайжамцын судлал*. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.

**Мянгад Эрдэмт.** 2019. *Зүүнгарын үсэг бичгийн ертөнц: Илийн голын урсгал дагуу оронд хадгалагдаж байгаа тод үсгийн дурсгалт бичгийн судлал*. Ляонянгийн Үндэстний хэвлэлийн хороо.

**Сэцэн Ш., Сүхбаатар Н.** 2018. *Зая бандида Намхайжамц судлалын эш хэрэглэгдэхүүн*. Улаанбаатар.

乌力吉. 2004年第五期. “近年发现的“布顿佛教史”蒙文译本评价”. “佛教文史”.